

Агуулга

1. Төслийн товч танилцуулага.....	2
2. Байгаль орчны суурь судалгаа.....	9
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	19
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	20
1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	22
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	31
3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	32
4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	33
5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	33
6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	35
7. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	36
8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	38
9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	41
10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт.....	43
11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	45
5. Байгаль орчинд зарцуулсан төсөв.	
6. Дүгнэлт	
7. Хавсралт	

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**


ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ордын байршил, физик газарзүй: Тусгай зөвшөөрлийн талбай нь Сүхбаатар аймгийн Уулбаян сумын нутагт ашиглалтын MV-015610 тусгай зөвшөөрөлтэй, нийт 158.39 га талбайг эзлэн оршдог.


Хүснэгт 1.

Тусгай зөвшөөрөл №	Олгосон он сар өдөр	Хугацаа /жил/	Цэгийн дугаар	Уртраг /град мин сек/	Өргөрөг /град мин сек/
Газарын солбилцол нь:					
L-46-49					
MV-015610 /158.39га/	2010.06.29	30	1	112° 52' 0.71 ^{II}	46° 43' 49.74 ^{II}
			2	112° 51' 7.37 ^{II}	46° 43' 49.74 ^{II}
			3	112° 51' 7.38 ^{II}	46° 44' 35.05 ^{II}
			4	112° 52' 072 ^{II}	46° 44' 35.05 ^{II}

Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл



зураг-1 үйлдвэрийн байршилын зураг




Зураг 2. Ашиглалтын талбайн байршилын тойм зураг

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

Дэд бүтцийн объектууд

Ус хангамж: Манай уурхайн үйлдвэрийн ус хангамжийг усны өрөмдлөг хайгуур 7 цооногийн худгийн барилга байгууламжийг “ЭкоВатер”ХХК гүйцэтгэж хүлээлгэн өгсөн ба ус хангамжийн систем асуулгүй ажиллаж байгаа.

Ус дамжуулах системийн усны эх үүсвэр нь Баруун-урт хотоос баруун хойт зүгт дунджаар 35км, Уулбаян сумаас зүүн хойт зүгт дунджаар 50км–т, үйлдвэрийн хэсгээс баруун хойт зүгт дунджаар 5-6км–т орших Тойромын нуурын хөндийд 7 гүний худгааг усыг татаж ус цуглуулах шугамаар дамжуулан усан санд хуримтлуулна. Гүний худгуудаас усан сан хүртэл нэгдүгээр өргөлтөөр шууд хүргэнэ. Энэ усан сангаас үйлдвэрийн ус хэрэглэнд өөрийн урсгалаар өгөх ба хэрэглэсэн усаа цэвэрлэн дахин хэрэглэх зарчмаар ажиллана.



Зураг 3. Үйлдвэрийн усан сан, насос станцын хяналтын самбар




Зураг 4. Худгийн барилга, цахилгаан хангамж

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

Цахилгаан хангамж: Ил уурхайн болон баяжуулах үйлдвэр, тосгоны цахилгааныг Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Уулбаян сумын 35кВ-ын өндөр хүчдэлийн шугамаас цахилгаан эрчим хүч авсан ба мөн Баруун-Урт хотоос 110 кВ-ын өндөр хүчдэлийн шугамыг татаж 110/35/10 кВт-ын дэд станцыг барьж улсын комисст хүлээлгэн өгсөн ба үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэхээр ашиглах болно. Энэ жилийн хувьд 10-р сард ус хангамжийн систем, тэрэх материалын агуулах руу тус тус 10 кВ-ын шугам татсан болно.

Үйлдвэрийн гадаад цахилгаан хангамжийн бүдүүвчийг доорх зурагт үзүүлэв.



Зураг 5. Төслийн цахилгаан хангамж

Тосгон орон сууц: Үйлдвэрийн ажиллагсдын байрыг Цариурт Овоо уурхайн хойно 1.0-1.5 км зайд байгуулсан. Бүх ажиллагсдын 10 орчим хувь нь уурхай дээр баригдсан нийтийн орон сууцанд, үлдсэн нь Баруун урт хотоос тусгай тээврийн хэрэгсэлээр зөөгдөн ажиллаж байна. Мөн үйлдвэрийн захиргааны үйлчилгээний байруудыг үйлдвэрийн объектуудын дэргэд барьсан. Энд захиргааны ажилтнуудын контороос гадна хоолны газар, халуун ус үйлдвэрийн дотоод холбоо, эмнэлэгийн цэгийг байрлаж байна.

Засвар, техникийн үйлчилгээний газар ба агуулахын аж ахуй: Уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь уулын механик тоног төхөөрөмж, авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос зэргийг хүлээн авах, хадгалах тавьж олгох зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

ХУЧИН ЧАДАЛ, ТЕХНИК ТЕХНОЛОГИ

Ил уурхайн хүчин чадлыг жилд 1300.0 мян.тн хүдэр олборлон баяжуулахаар ТЭЗҮ-д тусгасан ба ашиглалтын жилийг 58 жил гэж тооцсон байна. Төмрийн хүдрийн нойтон соронзон аргаар баяжуулж 68%-ийн агуулгатай баяжмал зах зээлд гаргана.

2024 оны уулын ажлын төлөвлөгөөнд баяжуулах үйлдвэр 1300000тн хүдэр боловсруулахаар төлөвлөсөн боловч үйлдвэр цахилгаан хангамжийн хүрэлцээ болон бусад хүчин зүйлийн улмаас нийт хүчин чадлын 40%-иар туршилтын журмаар ажиллаа. Ил уурхайгаас ирэх хүдрийг 700мм-ийн ширхэглэлтэй хүдрийг 3 шатны бутлалт, 2 шатны нунтаглалтаар -0.074мм (85%) болгож үндсэн болон 2 шатны цэвэрлэгээний нойтон соронзон сепаратороор баяжуулж төмрийн баяжмал гарган авал бөгөөд хаягдлыг өтгөрүүлэгч, шүүлтүүрийн тусламжтай шүүн шахаж хатуу байдалтай хаягдал гаргана.

Хүдэр баяжуулж байгаа технологи нь хүдэр дэх ашигт эрдсийг аль болох өндөр хувиар ялган авах зорилготой бөгөөд үйлдвэрээс гарч байгаа технологийн хаягдал нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байхаар шийдэгдсэн байна.

УУЛ ТЕХНОЛОГИЙН ХЭСЭГ

Цахиурт Овоогийн төмрийн ордын хайгуул хийгдсэн хүдрийн биетүүд нь 2 хэсэг газар тархсан ба тэдгээрийн нэг нь гадаргууд ил гарсан нөгөө нь 20м хүртэл газрын гүнд сөвсгөр хурдсаар хучигдсан байдаг. Уг ордын хүдрийн биетүүд нь 970-1015 м-ийн харьцангуй өндөртэй /өндөрийн зөрүү-45м/ тухайн районы хувьд газрын гадаргын эерэг хэлбэрүүдэд оршиж байгаа нь тодорхой гүнд хүртэл ордыг ил аргаар олборлох боломжтой гэж ТЭЗҮ-д туссан байна.

Хүдрийн-Өмнөд биет 650м урт, 440м өргөн ба Хойд биет нь 540м урт, 340м өргөн хэмжээтэй ба хоёул урагш 45-65° уналттай байдаг нь ил аргаар ашиглах бүрэн боломжтой.

Хүдрийн эзэлхүүн жин хүдэр дэхь төмрийн агуулгаас шууд хамааралтай байх ба нөөц тооцсон хүрээллийн хэмжээнд дунджаар 4,27тн/м³ байна.

Агуулагч чулуулгийн эзэлхүүн жин: роговик 2,7-3,2тн/м³ , шохойн чулуу 2,8-3,1тн/м³ боржин 2,7-2,95тн/м³ гэж тодорхойлогдсон. Ордын усжилт бараг байхгүй, өрөмдлөгийн явцад ан цавын шүүрлийн ус бараг илрээгүй нь ил аргаар ашиглалтыг явуулахад таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

Хүдрийн чийгшилтийг тодорхойлоогүй. Практикаас үзэхэд исэлдлийн бүсээс доош /40-50 м/ орших хүдрийн чийгшил 1%-иас ихгүй байдаг. Исэлдсэн хүдрийн чийгшил 2%, ховроор 3% байдаг. /Төмөртэй Овоо, Элстэй/. Чийгшилтийн ийм хувь нь чулуулгийн физик-механикийн шинж чанарт /хатуулагт/ нөлөөлөхгүй.

“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хөрс хуулалтын коэффициент эзэлхүүний аргаар бодсон ба ил уурхайн улыг хүдрийн биетээр, ханын налуугийн өнцгийг сэвсгэр ба ан цав ихтэй чулуулагт /VIII-X хатуулаг 40-50м/ 45°-иас ихгүй, ан цав багатай талстлаг чулуулагт /X-XII зэрэг/ 55-60°-д тооцсон.

Ил уурхайн хил хязгаар, түүний хүрэн дэх хүдрийн нөөц

Цахиурт овоогийн төмрийн хүдрийн ордын ил уурхайн гүнийг тогтоохдоо: Эхний 10 жилд 955-р үнэмлэхүй түвшин хүртэл ашиглана. Харин ил уурхайн хүрээ хязгаарын дараах байдалтай байна.

- Ил уурхайн баруун хязгаар - хайгуулын VI шугамын 960-р түвшингөөс суналын дагуух хажуу уруу хүртэл 420-ын налуутай татсан шугамын газрын гадаргатай огтлолцсон цэгүүд
- Ил уурхайн зүүн хязгаар - хайгуулын XII шугамын 965-р түвшингөөс суналын дагуух хажуу уруу 440-ын налуутай татсан шугамын газрын гадаргатай огтлолцсон цэгүүд
- Ил уурхайн ёроолын гүн - 955-р түвшин
- Ил уурхайн хойд хязгаар - 955, 960-р түвшингүүдээс хэвтээ хажуу уруу 440-ын налуутай татсан шугамын газрын гадаргатай огтлолцсон цэгүүд
- Ил уурхайн урд хязгаар 955, 960-р түвшингүүдээс босоо хажуу уруу 430-ын налуутай татсан шугамын газрын гадаргатай огтлолцсон цэгүүд болно. Тус уурхайн хүрээ хязгаар нь 15610А ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай багтаж байгаа болно.

Уурхайн жилийн хүчин чадал, ашиглах хугацаа

Ил уурхайн хүчин чадлыг жилд 1.3 мян.тн хүдэр олборлон баяжуулан 58 жил ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан байна. Төмрийн хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулна.

Уурхайн ажиллах горим

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээнээс хамааруулан жилийн турш, долоо хоногт амралтын нэг өдөртэй, 8 цагийн үргэлжлэлтэй 3 ээлжээр ажиллуулахаар төлөвлөв. Уурхайн жилд ажиллах хоногийг дараах байдлаар тооцоолов. Үүнд:

- Жилийн нийт хоног - 365
- Үндэсний баяр, ёслолын хоног - 6
- Өвлийн улиралын сул зогсолт -60
- Цаг агаарын нөхцлийг тооцсон хоног - 22
- Уурхайн жилд ажиллавал зохих хоног 240 хоног байна.

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

Ордыг нээх ба ашиглах дараалал

Гадаргын хувьд ухаа гүвээ, намхан толгодорхог гадаргуу бүтэцтэй тал хээрийн бүтэцтэй юм. Талбайн хэмжээнд хамгийн өндөр өргөгдсөн цэг болох талбайн төв хэсэгт оршиж байна. Цахиурт-Овоо нь далайн түвшинээс дээш 1005.9 м, хамгийн нам дор газар нь Давстай нуурын хөндийд 900м-ийн үнэмлэхүй өндөртэй байх бөгөөд харьцангуй өндөржилт 105м орчим байна.

Ил уурхайн үндсэн хэмжээсүүд

Ордын өмнөд ба хойд хүдрийн биетүүдийг тус тусдаа 2 ил уурхай хүрээнд хөрөх хуулалт, хүдэр олборлолтын ажлыг гүйцэтгэнэ. Ил уурхайн хил хязгаарыг тогтоохдоо бодитой В нөөцийг бүрэн авахаар (нарийвчилсан хайгуулын ажлаар нөөцийг нь тогтоох бодсон хүдэр) дэвсгэр болон зүсэлт зургууд дээр байгуулан ажлаар гүйцэтгэнэ.

Мөн хөрс хуулалтын дундаж коэффициентыг тогтоохдоо ил уурхайг эцсийн байдлаар зурсан дэвсгэр болон босоо, хөндлөн зүсэлт зургууд дээр доголлуудыг хоёрлосон хэлбэрээр байгуулан, түвшин бүрээр хөрс хуулалт, хүдэр олборлолтын ажлын хэмжээний гарган хөрс хуулалтын коэффициентуудыг тодорхойлж тэдгээрийн дундажийг авсан байна.

Уурхайн үндсэн хэмжигдэхүүнүүд:

Хоёрлосон доголын өндөр 20м

Хөрс хуулалтын мөргөцгийн өндөр 10м

Хүдэр олборлолтын мөргөцгийн өндөр 10м

Мөргөцгийн налуугийн хэмжээ 650

Ажлын бус доголын аюулгүйн зай 6м

Ажлын доголын аюулгүйн өргөн 10м-н олборлолтын болон хөрс хуулалтын доголд 3м-н тус тус тооцоолон зурсан болно.

Авто замын өргөн /ил уурхайн дотоод/ 15-25м

Авто замын налуугийн хэмжээ /ил уурхайн дотоод/ 80%

Ил уурхайн улны хэсгийн хамгийн бага өргөн 30м

Ил уурхайн ерөнхий налуугийн өнцөг 34-450

Хөрсний гадаад овоолгын налуугийн өнцөг 450

Шимт хөрс хуулалт.

Ордын хөрсний чулуулаг нь дээд хэсгээрээ буюу 0.2-0.5 метр г н х ртэл өгөршилт автагдсан сэвсгэр элюваль хурдаснаас, доод хэсгээрээ хатуу чулуулгаас тогтоно. Пржи шимт хөрсийг хуулахдаа 0.2-0.5метрээс ихг й зузаантайгаар сийрэгжилтийн ажлы хийлг йгээр шууд экскаватораар утган автосамосвалд ачин ил уурхайн үржил шимт хөрсний гадаад овоолгод байрлуулна. Шимт хөрсийг хөрс хуулалтын хослол болох 2.0м3-ын утгуурын багтаамжтай CAT-329D маркийн экскаватор, 40тн даацтай TR-45 маркийн автосамосвалын хослолоор хуулна.

Шимт хөрсийг уурхайн талбайн гадна 1-1.5км зайд урт удаан хугацаанд хадгалах овоолгод зөөвөрлөж хураана. Өрнөлтгүй болсон овоолго, уурхайн бүрэн ашиглагдсан газарт техникийн нөхөн сэргээлт хийсний дараа шимт хөрсөөр хучна.

үндсэн хөрс хуулалтын ажил: үндсэн хөрсний чулуулгын хатуулаг нь VI-VII зэрэглэлд хамаарагдаж байгаа нь хөрсний чулуулгийг авахдаа урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгж лэлтийн ажлыг хийсний дараа шилж лэх болно. Хөрсний чулуулгыг сийрэгж лсний дараа экскаватороор автосамосвалд ачин ил уурхайн гадна овоолгод байрлуулна. Хөрс хуулалтын ажлын догол нь 5м өндөртэй байна. Хөрс хуулалтын ажилд 2.0м3 утгуурын багтаамжтай шанагатай гидравлик экскаватор ажиллана.

Хүдэр олборлолт: Хөрсний доголтой нэгэн адил, суналын дагуу чиглэсэн уурхайн х дэр олборлолтын догол нь 5м өндөртэй байна. Хүдэр олборлолтонд 2м3-ын багтаамжтай шанагатай гидравлик экскаватор ажиллана.

Уулын идсэн техник дийн х чин чадал, хэрэгцээний тооцоо

Уурхайд дараах нэр төрлийн техникүүд ажиллана. Үүнд:

- 5м3-ийн утгуурын багтаамжтай WK-4D маркийн SUN HONG фирмийн шууд утгуурт экскаватор
- 235 кВт -ийн х чин чадалтай SHANTUI фирмийн SD32 маркийн бульдозерууд
- 65 тоннын даацтай TEREХ фирмийн автосамосвалууд
- 250мм-ийн диаметртэй KY-250D маркийн өрмийн машинууд
- 3м3 -н шанаганы багтаамжтай ZL-50 маркийн утгуурт ачигчууд зэрэг болно.
- Тэсэлгээний цооног цэнэглэгч машин
- Автогрейдер
- Туслах машин механизм (үйлчилгээний машинууд, кран, гэрэлтүүлгийн станци г.м.)

БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ СУДАЛГАА

Цахиурт Овоо уурхай оршиж байгаа орчмын бүс нутаг болох Уулбаян сумын нутаг дэвсгэрийн уур амьсгал нь физик-газарзүй, байгалийн нөхцөл болон газрын гадаргуугийн янз бүрийн байдлаас хамааран харилцан адилгүй хамааралтай байдаг бөгөөд ухаа гүвээ намхан толгодорхог бүсэд хамаарах ба эх газрын эрс тэс хуурай халуун бүсэд хамаарна.

Уулбаян сумын нутаг хотгор гүдгэрийн ялгаа багатай учраас өвөл зуны температурын хэлбэлзэл төдий л их биш байдаг. Жилийн хамгийн хүйтэн сар нь I дүгээр сар бөгөөд агаарын дундаж температур -21.1°C, хамгийн их температур 1.0°C, хамгийн бага температур -39.6°C, хамгийн дулаан сар нь 7 дугаар сар бөгөөд агаарын дундаж температур 21.7°C, хамгийн их температур 38.4°C, хамгийн бага температур 2.1°C байдаг.

Хөрсний гадаргын температурын тухайд I дүгээр сард дундаж температур -21.3°C, хамгийн их температур 2.1°C, хамгийн бага температур -39.0°C, 7 дугаар сард дундаж температур 27.9°C, хамгийн их температур 60.5°C, хамгийн бага температур 8.1°C байдаг.

Уулбаян сумын температурын сар бүрийн утгыг дараах хүснэгтэд үзүүлэв.


Хүснэгт 2

Уулбаян сумын температурын үзүүлэлт

Сар үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Агаарын температур												
Сарын дундаж, °C	-22.1	-17.3	-7.7	2.9	11.2	17.4	20.1	18.4	12.3	2.5	-9.7	-18.8
Хамгийн их, °C	1.0	14.2	18.5	26.4	34.9	36.0	38.4	35.4	30.4	29.0	12.2	0.4
Хамгийн бага, °C	-39.6	36.7	-26.8	-17.8	12.1	1.2	2.1	2.0	-7.1	-24.0	-30.1	-39.1
Хөрсний гадаргын температур												
Сарын дундаж, °C	-22.0	-16.7	-4.3	8.2	18.5	25.3	27.2	24.4	16.9	4.1	-9.0	-18.9
Хамгийн их, °C	2.1	15.6	26.6	41.7	51.7	60.6	60.5	64.3	62.6	46.5	24.1	8.6

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**


Хамгийн бага, °C	29.0	38.7	-28.4	-18.6	-15.8	0.6	8.1	-1.7	-8.2	20.0	-25.4	-35.3
------------------	------	------	-------	-------	-------	-----	-----	------	------	------	-------	-------



Зураг 6. Уулбаян сумын агаарын температурын жилийн явцыг харуулсан зураг


Газар ашиглах эрхийн гэрчилгээтэй эдгээр талбайнуудын орчмын нутагт 12-2 дугаар сард сарын дундаж температур хасах 17.3°C-аас хасах 22.1°C, хамгийн бага температур хасах 21.0-аас хасах 28.0°C хүрдэг бол хамгийн дулаан 7 дугаар сард дундаж температур нэмэх 20.1°C, хамгийн их температур нэмэх 32.4°C, хамгийн бага температур нэмэх 23.1°C хүрнэ.

Уулбаян сумын жилийн, дулаан ба хүйтэн улирлын дундаж температурын олон жилийн явц болон түүний өөрчлөлтийн хандлагын байдлыг дараах зураг үзүүлэв. □ ид




Зураг 7. Уулбаян сумын жилийн дундаж температурын олон жилийн явц ба түүний өөрчлөлтийн хандлага

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**



Зураг 8. Уулбаян сумын дулаан улирлын дундаж температурын олон жилийн явц
ба түүний өөрчлөлтийн хандлага



Зураг 9. Уулбаян сумын хүйтэн улирлын дундаж температурын олон жилийн явц
ба түүний өөрчлөлтийн хандлага

Дээрх графикан зургуудаас үзэхэд энэ орчмын нутагт 1983-2010 оны хооронд жилийн дундаж температур 1,1 градусаар, дулаан улирлын дундаж температур 1,7 градусаар, хүйтэн улирлын дундаж температур 2.0 градусаар тус тус дулаарсан байна. Ерөнхийдөө дулаарах хандлага байгаа боловч өвлийн дулааралт буурах төлөвтэй байна.

Энэ бүс нутагт анхны цочир хүйтрэл нь дунджаар 9 д гээр сарын 26-ний үеэр ажиглагдах бөгөөд хамгийн эртдээ 9 д гээр сарын 4, хамгийн оройдоо 10 дугаар сарын 15-ны үеэр, эцсийн цочир хүйтрэл нь дунджаар 5 дугаар сарын 14-нд, эртдээ 4 д гээр сарын 29-нд, хожуудаа 6 дугаар сарын 1-ны үед болдог байна. Иймээс цочир хүйтрэлгүй байх хугацаа нь дунджаар 135 хоног, хамгийн их хугацаа нь 171 хоног, хамгийн багас хугацаа нь 105 хоног үргэлжлэх тохиолдол ч бий.

Хоногийн дундаж температур нь 0°-ыг дайрч дулаарах нь хавар 4 д гээр сарын 5-нд, хүйтрэх нь 10 дугаар сарын 25-нд болж, ойролцоогоор 203 хоног үргэлжилдэг бол +5°-

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

ыг дайрч дулаарах нь хавар 4 д гээр сарын 20-нд, хүйтрэх нь 10 дугаар сарын 10-нд буюу 173 хоног байна.

Харин -5°-ыг дайрч хүйтрэх нь намрын улирлын 11 д гээр сарын 8-оор болж дулаарах нь хаврын улирлын 3 дугаар сарын 21 хүртэл 133 хоног тус тус үргэлжилнэ.

Агаарын чийг, хур тунадасны талаар: Уулбаян сумын нутаг дэвсгэр нь нийтдээ хуурайдуу уур амьсгалтай бүсэд багтана. Агаар нь хуурай хөрснөөс ууриших чийгийн нөөц бага учраас жилийн дулаан улирлын дундаж харьцангуй чийгшил 30 хувь хүрнэ. 30 хувиас бага чийгтэй өдрийн тоо 51-62 өдөр байна. Агаар хуурайдуу учир хур тунадасны хэмжээ жилд 144.9-150.9 мм хэмжээтэй орно. Хүйтэн улиралд 6,0-45,0 мм тунадас ордог байна.

Энэ бүс нутгийн бас нэг онцлог нь монголын бусад нутгийн нэгэн адил нэг хоногт орсон тунадасны хэмжээ нь сарын нийлбэрээс давах тохиолдол байдаг. Тухайлбал, 1984, 1988, 2003, 2007 оны VI-X сард нэг хоногт орсон тунадасны хэмжээ олон жилийн дунджаас 6.9-84.8 мм-ээр, 1984 оны VI сард олон жилийн дунджаас 84.8 мм-ээр их хур тунадас орж байжээ.


Уулбаян сумын хур тунадасны үзүүлэлтийг дараах хүснэгтэнд харуулав. □ нд:

Уулбаян сумын хур тунадасны үзүүлэлт

Хүснэгт 3


I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Сарын нийлбэр, мм											
1.2	1.4	2.1	4.2	13.3	31.2	44.8	42.0	12.6	5.7	2.2	2.1
Хоногийн хамгийн их, мм											
2.9	3.1	3.4	20.4	16.2	116	38.5	97.7	19.5	19.6	5	3.1
Хоногийн хамгийн их тунадас орсон он											
2001	2003	2009	2003	2002	1984	1994	1988	2003	2007	1989	1984

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**




Зураг10. Уулбаян сумын хур тунадасны жилийн хуваарилагдал

Нийлбэр тунадасны хэмжээнд гарч буй өөрчлөлтийг тодорхойлохын тулд цагаан уурын Уулбаян станцын мэдээгээр жилийн болон дулаан, хүйтэн улирлын тунадасны олон жилийн явцыг гаргаж өөрчлөлтийг нь авч үзлээ. Хур тунадасны олон жилийн явцыг авч үзэхэд 1983-2010 оны хооронд бараг өөрчлөлтгүй байна. Хүйтэн улирлын нийлбэр тунадас цаашид бага зэрэг нэмэгдэх хандлагатай байна.




Зураг 11. Жилийн нийлбэр тунадасны олон жилийн явц, түүний өөрчлөлтийн хандлага

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**



Зураг 12. Дулаан улирлын нийлбэр тунадасны олон жилийн явц, түүний өөрчлөлтийн хандлага



Зураг 13. Хүйтэн улирлын нийлбэр тунадасны олон жилийн явц, түүний өөрчлөлтийн хандлага

Салхины талаар: Уулбаян сумын нутаг дэвсгэр нь нэлээд салхитайд тооцогдоно. Жилийн салхины дундаж хурд нь 3.3-3.7 м/с байна. Ялангуяа 4 ба 5 дугаар сарын хооронд маш их салхитай байдаг. Хүчтэй салхи буюу 15м/с -ээс их салхитай өдрийн тоо олон жилийн дунджаар 3-5 өдөр байдаг.

Энэ 6 с нутагт 10 м/с-ээс их салхитай өдрийн тоо дунджаар 58-136 удаа ажиглагдана. Салхины зонхилох чиглэл нь баруун з гэс салхиладаг. Тэгэхдээ жилийн хүйтэн улирлын саруудад баруун өмнөдийн ба баруун хойд зүгийн салхины давтагдах нэмэгдэх хандлагатай байдаг ажээ.

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

Сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Үзүүлэлт												
Салхины дундаж хурд, м/с	2.4	2.5	3.6	5.0	4.9	4.1	3.4	3.0	3.0	3.2	3.0	2.3
Их хурд, м/с	14	14	20	20	20	17	14	14	18	20	20	14


Хүснэгт 5


Уулбаян сумын салхины чиглэлийн давтагдал (%)

Сар	X	ЗХ	З	ЗӨ	Ө	БӨ	Б	БХ
I	11.6	9.4	1.4	2.4	3.9	23.9	17.2	26.6
IV	12.3	11.8	5.1	2.2	4.0	15.8	18.6	25.1
VII	12.5	15.5	13.4	9.0	5.2	10.6	10.8	18.3
X	12.9	15.2	4.9	4.2	5.4	18.1	16.1	19.1

Дээрх х снэгтийн з лэлтээс зэхэд энэ бүс нутагт баруун, баруун хойд зүгийн салхи зонхилдог болох нь харагдаж байна. Тухайн орон нутгийн хотгор гүдгэрээс хамаарч салхины чиглэлийн давтагдал харилцан адилгүй байна.

Жишээлбэл:





Зураг 14. Салхины чиглэлийн давтагдал

Физик газарзүй: Гадаргын хувьд ухаа гүвээ, намхан толгодорхог гадаргуу б тэцтэй тал хээрийн б с юм. Талбайн хэмжээнд хамгийн өндөр өргөгдсөн цэг болох талбайн төв хэсэгт орших Цахиурт Овоо нь далайн түвшинээс дээш 1005.9 м, хамгийн нам дор газар нь Давстай нуурын хөндийд 900 м-ийн үнэмлэхүй өндөртэй байх бөгөөд харьцангуй өндөржилт 105 м орчим байна. Толгод, гүвээ нь мөлгөр, хавтгай оройтой аажим налуу хажуутай, уужим тавиу өргөн хөндий хөгжсөн байдаг.

Ус зүй: Ордын талбай нь Монгол орны гидрогеологийн мужлалаар Дорнод Монголын тал хээрийн их мужийн усан сүлжээ муу хөгжсөн талбайд хамаарна. Ашиглалтын талбайн районд хужир марз бүхий шавартай тойром тархсан, дэрстэй томоохон өргөн хөндийнүүдэд ус нь ихэвчлэн шургамал, хур тунадас элбэг үед ил гардаг. Нутгийн ард иргэд гар болон гүний худаг ашигладаг.

Уур амьсгал: Уур амьсгалын хувьд эх газрын эрс тэс хуурай, халуун бүсэд хамаарагдах бөгөөд хоногийн болон жилийн температурын зөрүү эрс өөрчлөлт ихтэй нутаг юм. Хамгийн халуун үе нь 7-8 сард $+40^{\circ}\text{C}$ (сарын дундаж $+20^{\circ}\text{C}$) хүрэх бөгөөд 1-р сард -35°C (сарын дундаж -20°C) хүртэл хүйтэрдэг байна. Салхины дундаж хур 2.6м/с, өвөл ба зундаа тогтуун, (0.1-2.3м/с), хавартаа 35.9м/с хүртэл ширүүсдэг. Жилд дунджаар 150мм орчим тундас унадаг бөгөөд түүний 70% нь зуны улиралд (зөвхөн 7-р сард 258мм хүрч байсан тохиолдол бий) унадаг.

Хөрс, ургамал ба амьтны аймаг: Ургамлын б рх л сайн хөгжсөн бөгөөд тал хээрийн бүсийн ургамал тархсан. Амьтны аймгийн төрөл зүйлийн хувьд цөөхөн төрөл зүйл, цөөхөн тоо толгойтой байдаг. Гол төлөв н длийн туурайтан болон мэрэгчид, шувууд энд нутагладаг.

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Улаанбаатар хотоос з н урагш 520км, Өндөрхаан хотоос з н урагш 180км, Баруун-Урт хотоос баруун хойш 30км-т оршиж

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

ба дэд бүтцийн хувьд дунд зэргийн хөгжсөн, төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон. Үүрэн телефоны операторууд энэ районы бүх сумдад байдаг. Нутгийн оршин суугчдын дийлэнх нь нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг. Хүн амын нягтрал багатай боловч ажиллах хүчний хувьд хангалттай. Орд нь Уулбаян сумын төвөөс зүүн хойш зүгт 40км орчим, Төмөртэйн Овооны цайр төмрийн уурхайгаас баруун зүгт 40 км-т оршино. Мөн Баянт мэн төмөр замын өргөөнөөс баруун урагш 250 км зайд оршино. Хамгийн ойр орших томоохон суурин Баруун-Уртад засаг захиргааны байгууллагууд, их, дээд боловсролтой ерөнхий боловсролын сургууль, хүн эмнэлэг, эмийн сан, шуудан холбооны салбар шатахуун түгээгүүр ба цаг уурын станц, хувийн хэвшлийн худалдаа үйлчилгээний цэгүүд байдаг. Сүүлийн жилүүдэд тус бүс нутгийн хэмжээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн геологийн судалгаа идэвхжих хандлагатай байна. Физик-газар зүйн хувьд районы хэмжээнд ямар нэгэн төрлийн ажил үргийг гүйцэтгэхэд онцын саад бэрхшээлгүй, цаг уурын нөхцөл байдал тааламжтай. Орон нутгийн газрын хэлбэр бүтцийн зүйн хувьд тээврийн хэрэгслэлийн бүх төрлийг саадгүй ашиглах боломжтой.

Геологийн судалгааны түүх: Монгол-Унгарын хамтарсан экспедицийн геологч О.Балла нар 1966-1967 онд 1:200000 харьцалтай геологи-гидрогеологийн зураглалын ажил, Дорнодын геологийн удирдах газрын харьяа Салхитын Монгол-Германы ангийн геологич К.Зем нар 1980-1982 онд 1:200000 харьцалтай геологийн зураглалын ажил хийж энэ бүс нутгийн геологийн тогтоцогч тодруулсан байдаг. Энэ ажлаар Цахиурт-Овоогийн төмрийн ордыг анх илрүүлж, анхны үнэлгээ өгсөн байдаг. К.Зем нар 1:50000 харьцалтай геологийн зураглал-ерөнхий эрлийн ажлаар манай хайгуулын талбай дээр карбонат-тунамал чулуулгийг доод девонд, суларсан хайргабазальт хий конгломерат, базальт, андезитбазальтыг доод цэрдийн Цагаан цавын формацид жигд жижиг-дунд мөхлөгт боржинг төрөл Перм-д хамааруулсан байдаг. Тус тайлан Цахиурт-Овоогийн төмрийн илрэл 350м урт, 35-40м өргөн магнетит-гематитын скарны биет гэж тодорхойлж бичээд цаашид судлах шаардлагатай гэж нэлсэн байдаг. Хамгийн сүүлд 2009 онд “Смарт капитал” ХХК нарийвчилсан хайгуулын ажил явуулж түүний үр дүнгээр геологич С.Ганбаатар, Р.Санзайдорж, Б.Энхжаргал, У.Болдбаатар, Д.Наранцэцэг нар үр дүнгийн тайлан боловруулан тус ордын нөөцийг улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Геоморфологи: Цахиурт овоогийн төмрийн хүдрийн орд нь Дорнод Монголын үндсэн төрх болох намхан гүвээ толгод бүхий талархаг гадаргуутай. Талбайн хамгийн өндөр цэг Цахиурт овоо нь далайн түвшингээс дээш 1015м, хайгуулын талбайд орших хамгийн нам цэг Цахиурт овоогоос баруун хойш орших шорвог ус тойром 965м харьцангуй өндөршилт 50м байна. Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай болох Цахиурт овоо орчимийн бүс нутаг геоморфологийн тодорхой элементүүд ялгах муу нэгэн төрлийн гадаргуу хөгжсөн байдаг. Зөвхөн чулуулгийн гарш илэрсэн багахан хэгүүд дээр элэгдэл-зөөгдлийн гадаргуу болох бол үлдсэн хэсэг бүхэлдээ хуримтлалын гадаргад хамаарахаар байна.

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

Тус ордын Өмнөд хүдрийн биетийн магнетит-гематитийн биетийн гаршийн өндөр нь 1015м өндөртэй Цахиурт Овоо нэртэй жижиг толгой дээр илэрсэн байдаг бол Хойд хүдрийн биет түүнээс 40м доор байрлах бөгөөд сэвсгэр хурдсаар бүрхэгдсэн байдаг.

Гидрогеологи: Цахиурт Овоогийн төрийн хүдрийн ордын хайгуулын талбайн орчимд урд өмнө гидрогеологийн нарийвчилсан судалгаа, түүний дотор улс ардын аж ахуйн томоохон объектуудын усан хангамжийн эх булагийг илрүүлэх чиглэлийн ажил бага хэмжээгээр хийгдэж байсан байна. Гэвч тэдгээр нь Цахиурт Овоогийн ордод 3-5км зайтай байдаг.

Районы геологийн бүтэц чулуулгийн ерөнхий усжилтын хэмжээгээр судалгаанд хамрагдсан талбайд дараах уст бүрдэлүүдийн ялган үзэж байна. Үүнд:

1. Доод девоны хувирмал карбонат-терриген уст бүрдэл /D₁/
2. Түрүү пермийн гүний интрузив уст бүрдэл /УР₁/
3. Доод цэрдийн вулканоген-терриген уст бүрдэл /R₁/
4. Дөрөвдөгчийн делюви-пролювийн сэвсгэр хурдасны уст бүрдэл /Q/ эдгээр болно.

Доод девоны хувирмал карбонат-терриген уст бүрдэл /D₁/: Доод девоны хувирмал карбонат-терриген уст бүрдэл талбай орчмын нутагт бага хэмжээтэй тархсан байдаг. Ус агуулагч чулуулгууд ан цавархаг гантгяжсан шохойн чулуу, алевролит, элсэн чулуугаас бүрдэнэ. Эдгээр чулуулаг нилээн сул усжилттай. Чулуулгуудын усжилтын хэмжээ ан цавшилт, тэдгээрийн хоорондын холбоо, нэвчих гүнээс ихээхэн хамаардаг. Гэвч уг чулуулаг нь маш бага тархалттай байдаг нь усны хэмжээний хувьд ач холбогдолгүй болж байна.

ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН

Биосферийн элементүүд	Биосферийн элементүүд уулын үйлдвэрлэл үзүүлэх нөлөө	Гарч болзошгүй үр дагавар
Хөрс	<ul style="list-style-type: none"> • Баяжуулах үйлдвэрийн барилга, байгууламж ашиглах • Ус хангамжийн байгууламжийн шугам сүлжээг барих, ашиглах • Хүдрийн овоолого байгуулах/хөрс хуулах/ • Хаягдлын овоолого байгуулах • Технологийн болон гадаад тээврийн зам байгуулах 	<ul style="list-style-type: none"> • Газрын гадаргууны деформаци, хөрс эдэгдэл талбайн төрхийн өөрчлөлт • Газрын доорхи урсгал багасалт • Нуурын усны хэмжээг нөлөөлөх өөрчлөлт • Шатах, тослох материал хөрс бохирдох
Ус	<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрийн усны хэрэглээг хянах • Ил задгай талбайд ус тогтох 	<ul style="list-style-type: none"> • Газрын доорхи бохирдлын гадаргын усны нөөц, горноос чанар өөрчлөгдөх
Агаар мандал	<ul style="list-style-type: none"> • Баяжуулах үйлдвэрээс гарах тоосжилт • Хаягдлын овоолого тоосжилт үүсгэх 	<ul style="list-style-type: none"> • Агаарын тоосжилт хорт өвчин ихсэх
Ургамал	<ul style="list-style-type: none"> • Баяжуулах үйлдвэрийн барилга, байгууламж барих • Ус хангамжийн байгууламжийн шугам сүлжээг барих, ашиглах • Хаягдлын овоолого байгуулах • Технологийн болон гадаад тээврийн зам байгуулах 	<ul style="list-style-type: none"> • Ургамлан нөмрөг устгах, ургамлын төрөл зүйлс хомсдох, бэлчээр ургамал хомсдож бэлчээрийн талбай багасна
Амьтан	<ul style="list-style-type: none"> • Хүдэр баяжуулалт, ус хангамжийн систем 	<ul style="list-style-type: none"> • Баяжуулах үйлдвэрээс гаргах дуу чимээ ихэссэнээс амьтан дайжих, байршил өөрчлөгдөх

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“ЭМ ЭЛ Цахиурт овоо” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Уулаян сумын нутагт орших Цахиурт Овоогийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар олборлож нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь тухайн жилийн уурхайн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч ажиллах юм. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтоо биелүүлж ажиллахын тулд Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөө орчны хяналт шинжилгээний хөдөлбөрийг барьж ажилласан болно.

“ЭМ ЭЛ Цахиурт овоо” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлс хийх урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг тогтмол хянах, илрүүлэх уурхайн эдэлбэр газарт ногоон байгууламж нэмэгдүүлэх, уурхайн усны менежментийг сайжруулах, хог хаягдлын хэмжээ, хяналт шинжилгээний хөдөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьдаг.

Бид уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөдөлбөрийг хэрэгжүүлсээр ирсэн.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2024 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгосон. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байх болно.

эрх зүйн үндэслэл

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийг нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьсан.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 31.4 дэх заалт болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.6, 9.7 дахь заалт, 2019 оны 10сарын 29-ны өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгасан ажлын хэсгийн дүгнэлтээс гарсан зөвлөмж зэргийг удирдлага болгов.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөө зайлс хийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, явцад нь хяналт тавин ажилласан болно.

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 онд төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг уулын ажлын болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд болон төмрийн хүдрийн ордын хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн туршилтын ажлын үед хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээг авч ажиллалаа.

2024 онд төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг уулын ажлын болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан дараах арга хэмжээг авч ажиллаа.

- Хөрсний химийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн.
- Агаарын бохирдолтыг хэмжилт судалгаагаар тогтоох, тогтмол хугацаанд шинжлүүлсэн.
- Усны хяналт шинжилгээг орчны хяналт шинжилгээний хөдөлбөрт тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэсэн.
- Хөрс шатах тослох материалаар бохирдохоос сэргийлэх талаар инженер техникийн ажилчид, жолооч нарт сурталчилгаа хийдэг
- Ургамлын нөмрөгийн талхагдлаас сэргийлэхийн тулд олон салаа зам гаргахгүй, замыг тэмдэг тэмдэгжүүлж, хурдны хязгаарлалтын тэмдэгийг засаж тавьсан.
- Уурхайн үйл ажилгаанаас гарсан аюултай хог хаягдалыг бүртгэж цуглуулан сөрөг нөлөө үзүүлэхгүй нөхцөлд хадгалж түр хадгалах зөвшөөрөл гаргуулан ажиллаж байна.
- Уурхайн карьерт сэргийлж хийсэн торон хашааны бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж шаардлагатай тохилдолд засварласан
- Ус хангамжийн системийн хэвийн үйл ажиллагааг тогтмол хянадаг.
- Уурхайн карьер болон дотоод гадаад тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилтийг бууруулах үүднээс замын усалгаа тогтмол хийж ажиллаа.
- Уурхайн ажилчдад нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, болон хор саармагжуулах бүгээгдэхүүнээр хангаж ажиллаж байна.
- Уурхайн нийт ажилчдад байгаль орчны сургалт зохион байгуулав.
- Уурхайн дотоод тээвэрлэлтийн замыг засаж сайжруулав.
- Уурхайн гадаад тээвэрлэлтийн замыг засаж сайжруулав.
- Машин техникүүдийн яндан шүүлүүр суурилуулж техникийн үзлэг оншилгоонд хамруулсан
- Баяжуулах үйлдвэрийн тоос баригчийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллаа.

ДЭЭРХИ АЖЛУУДЫН ЗУРГАН МЭДЭЭЛЭЛИЙГ ХАВСАРГАВ.

“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Хөрс



Ус



Агаар

“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Замын тэмдэг тэмдэглэгээ засаж сайжруулсан байдал



Торон хашаа засварласан



**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**



Аюултай хог хаягдлыг агуулах



Тоосжилтоос урьдчилан сэргийлсэн байдал



**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**



Ажилчидад байгаль орчны сургалт



Уурхайн бүсийн зам

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**



Тээвэрлэлтийн зам

**УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
БУУРУУЛАХ, АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

Монгол улс Усны тухай хуулийн 28,6 28,7 29,1 –д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-ын 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн Е-2406-000104 тоот ус ашиглуулах дүгнэлт гаргуулан ажиллаа.

Үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэр 7 худагийн 2 худагийг ашиглаж байна. Газрын доорхи усны түвшин буурах сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх улсын хяналтын цооногийг БОАЖЯ-наас суурилуулж уг цооногууд улсын мэдээллийн санд мэдээлэл өгч байгаа бөгөөд тухайн хяналтын цоонгийн бүрэн бүтэн байдалыг хянаж хамгаалан ажиллаж байна. Мөн манай байгуулга ахуйн бохир усыг татан зайлуулах гэрээ Ууганбаатар гэх хувь хүнтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**



Хяналтын цооног




хяналтын цооногийн одоогийн байдал

Монгол улс Усны тухай хуулийн 28.4 28,6 28,7 29,1 –д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын гаргасан 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн Е-2406-000104 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны олгосон 2024 оны 09 дугаар сарын 04-ны өдрийн А/34 дугаартай ус ашиглах зөвшөөрөл олгох тухай тушаалыг үндэслэн Дугаар 0725 бүхий ус ашиглах гэрээг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаатай 1 жилийн хугацаатай гэрээ байгуулав. Мөн 2017 оны 03 сарын 28 өдөр Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхцалгүй гэсэн дүгнэлт гаргуулсан болно.

Энэ онд ус хангамжийн системийг 40%-ийг ашигласан ба үйлдвэрийн үйл ажиллагаа бүрэн хүчин чадлаар ажиллаагүй. Сүхбаатар аймгийн Дөрвөлж ХХК-аар Ф150мм голчтой хүйгэн усны тоолуурыг гүний худгын шугаманд суурилуулсан. Үйлдвэрийн технологийг ашиглах ус, зам талбай услах мод ногоон байгууламж услах чиглэлээр ус ашиглаж ус ашиглах гэрээнд заасны дагуу сар бүрийн 22-ний өдөр Аймгийн татварын байцаагчийг авчирч 2 тоолуурын заалтын бичилт хийж ус ашигласны акт үйлдэж төлбөрийг гэрээнд заасан хугацаанд хэтрүүлэлгүй төлдөг болно. 2024 оны 11 сарын 01 ны уурхайн үйл ажиллагаа хэвийн явж байна. усны төлбөр нийт **23899**м3 ус хэрэглэж усны төлбөр **49,518,728** төгрөг төлсөн байна.



Бохир усыг соруулж буй байдал



Тоолуурыг суурилуулж буй байдал

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

ГОЛОМТ БАНК
Сийн ойлгоны өмнөдүржүүлэлт

Цахим гүйлгээний баримт

Сэлтийн давлах дугаар: 121753878 Татсан огноо: 2022-05-31 14:13

Шилжүүлэгчийн дансны дугаар 1105038866 IBAN: MN52 0015 0011 0503 8866	Хүлээн авагчийн данс 1165117377 IBAN: MN03 0015 0011 6511 7377	Гүйлгээний дүн 5,088,240.00 MNT	Гүйлгээний төлөв Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ЭМ ЭЛ ЦАХИУРТ ОВОО ХХК	Хүлээн авагчийн нэр TAX	Гүйлгээний утга 32205034586037;41101258641;5452503;41101258641;3907655	Гүйлгээний огноо 2022-05-31

01 ГОЛОМТ БАНК ХУУЛБАР ҮЙСН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. © Голомтбанк ХХК.

Төлбөр төлсөн баримтаас

**“ЭМ ЭЛ ЦАХИУРТ ОВОО” ХХК-ИЙН УСНЫ ТООЛУУРЫГ
ХЭМЖСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ**

Баруун-Урт

2024.10.24

2024 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 10:30-12:35 цагийн хооронд Татварын хэлтсийн Татварын улсын байцаагч Д.Ганбямба, Эм Эл Цахиурт Овоо ХХК-ний дарга Байгаль орчны мэргэжилтэн Н.Амгаланбаатар нар уурхайн ажил эхлэхтэй холбоотой хугагийн усны тоолуурын заалтыг баталгаажууллаа.

д/д	Тоолуурын заалт	Өнгөрсөн сар	Энэ сар	хэмжээ	дүн
1	Тоолуур-1	0213703	0214955	1252	
2	Тоолуур-2	0185314	0191970	6656	
				7908	16,385,376.00

Ашигт малтмал баяжуулахад газрын доорхи ус ашиглах төлбөр:
1 м3 газрын доорхи усны үнэ 3700₮/м3x0.35x1.6=2072₮

- 3700₮/м3 – Умард гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорхи усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ
- 0.2 - /20% / 326-р тогтоолын 7/а/ газрын доорхи ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ
- 1.8 – Ашигт малтмал баяжуулахад газрын доорхи ус ашигласныг тооцох итгэлцүүр

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: ТУВ
ТАНИЛЦСАН: МЭРГЭЖИЛТЭН

Д.Ганбямба
Д.ГАНБЯМБА
Н.АМГАЛАНБААТАР

Усны тоолуур хэмжсэн акт

“Эм Эл Цахиурт овоо” ХХК

Хуудас 30

2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Цахиурт-Овоо” төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах, хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэр, ус хангамжийн байгууламжийн талбай орчмын газрын хэвлий, газрын гадарга, хөрс, гадаргын усан сүлжээ, ургамлан нөмрөгт үүсэх эвдрэлийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ авч, нөхөн сэргээх ажлын хэмжээ, холбогдох зардлыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам аргачлал, стандарт шаардлагын дагуу нарийвчлан тооцож нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулсан.

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-д заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайг зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх гэсний дагуу 2024онд орчны тохижилт хийх боломжтой талбайд ногоон байгууламжийн ажил хийгдэх бөгөөд мод тарилт, орчны тохижилтын ургамалжуулалтын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн ажилчидын тосгоны орчинд 250 уурхайн үйлдвэрийн орчинд 250ш ширхэг мод тарьж, суулгасан болно.





Уурхай



Кемп

3. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хөгжлийн нөлөөллийг зохистой бууруулахын тулд нөлөөллөөс зайлс хийх нөлөөллийг бууруулах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлага гарч байна. Иймд 2012 онд УИХ-аас баталсан Байгаль орчныг хамгаалах тухай. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулинд дүйцүүлэн хамгаалах асуудлыг тусган өгч эрх зүйн орчныг бүрдүүлж эхэлсэн.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөө илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцийн зорилго болно.

Бид 2024 онд дүйцүүлэн хамгаалах чиглэлээр орон нутгийн тусгай хамгаалалттай газарт болон биологийн олон янз байдлын амьдрах орчныг сайжруулах мөн МУ-ын шадар

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

сайд, БОАЖЯ-ны сайд, УУХҮ-ийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд нарын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Нөхөн сэргээлтийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах 167,А/698,А336,А/242 хамтарсан тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын /242/ хамтарсан тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Чиглэл хүргүүлэх тухай” 2020 оны 12 дугаар сарын 22-ны 01/8786 тоот албан бичигт заасны дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд Түвшинширээ сумын Бумбат нэртэй Х.Ө 46° 23,53.14” з.у 111° 36’ 39,40” солбицлолд орших эвдрэлд орсон 1га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж байгаа болно.

**4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Цахиурт-Овоо төмрийн хүдрийн ордын хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэр ус хангамжийн байгууламжийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийг бүсэд орших иргэд оршин суугчид айл өрх байгууллагыг зайлшгүй нүүлгэн шаардлагатай болсон тохиолдолд тэднийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулан гэж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд заасны дагуу 2014 оны 07 сард нутгийн малчин Н.Амарсанаагийн өвөлжөө баяжуулах үйлдвэрийн талбайд байсаныг нүүлгэн шилжүүлж харилцан тохиролцон гэрээ байгуулж зохих нөхөн олговрыг олгосон байдал бөгөөд 2021 онд нүүлгэн шилжүүлэх ажил төлөвлөгдөөгүй болно.

**5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Тус компани нь Сүххаатар аймгийн Уулбаян сумын нутаг дахь ашиглалтын МV-015610 А тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайд орших археологийн дурсгалыг авран хамгаалах малтлага судалгааны ажлыг 2011 оны 09 дүгээр 20-оос 10 дугаар сарын 20-ыг хүртэл нийт 30 хоногийн хугацаанд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгээр хийлгэсэн. Энэ хүү МV-015610 А тоот ашиглалтын талбайд байсан дурсгалуудыг Монгол Улсын соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 17 дугаар зүйлийн 10-г заасныг үндэслэн авран хамгаалах малтлага судалгаа хийж тухайн ашиглалтын талбайг чөлөөлсөн байна

Уг тусгай зөвшөөрлийн талбайд цаашид хийх геологи хайгуулын болон олборлолтын явц түүний дэд бүтэцийн барилгажилтын ажил гарах нөхцөлд эртний түүх соёлын ямар нэгэн дурсгал өртөхөөргүй болсон тул цаашид түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээг авахгүй.



Ашиглалтын талбай дахь Археологийн дурсгалыг авран хамгаалах малтлагын судалгааны ажлын үл мөр.

6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзолшгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Биелэлт	Баримтлах стандарт, аргачлал
<p>Байгалийн болзолшгүй гамшиг, аюулт үзэгдэлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах</p>	<p>Тэсрэх бодисын агуулах ШТМ-ын агуулах, химийн бодисын агуулахын аюулгүйн бүсийг тогтоож, дэглэмийг мөрдөж ажиллах.</p>	<p>2024 онд тэсэлгээны агуулах, клонк, химийн бодисын агуулах зэрэг объектуудад галын сараа, галын хор болон тэмдэг тэмдэглэгээ зэргийг стандартын дагуу байршуулан ажиллаж байна.</p>	<p>Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS5566:2008 MNS0640:89 MNS639:89</p>



ШТС



Тэсэлгээний агуулах



Химийн бодисын агуулах

7. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Болзолшгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Биелэлт	Баримтлах стандарт, аргачлал
<p>Химийн бодисын хадгалалт, ашиглалтын стандарт, дүрэм журам мөрдөөгүй улмаас болзошгүй эрсдэл үүсэх</p>	<p>Химийн бодисын аюулгүй ажиллагааны зааварчилгаа, журам төлөвлөгөө, хор аюулын лавлах мэдээлэл боловруулах, олшруулах, хэвлэх, ажлын байр бүрт болон агуулах, гадаа талбайд байрлуулах</p> <p>Химийн бодис, бүтээгдэхүүний сав баглаа боодлыг цуглуулах, аюулгүй хадгалах, хоргүйжүүлсэн зайлуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлтэйгээр зориулалтын цэгт тээвэрлэн хүргэх</p>	<p>Уурхайн даргаар аюулгүйн ажиллагааны зааварчилгаа батлуулан бодисын агуулах болон гаднах талбайд аюулгүйн тэмдэг тэмдэглэгээг байршуулан ажиллаж байна</p> <p>2022 оноос хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн байгуулага болох ЦЭЦҮҮХ ТРЕД ХХК гэрээ байгуулан зориулалтын цэгт хүргүүлэн ажилласан. 2024 онд химийн бодис болон сав баглаа боодлыг түр хадгалах зөвшөөрөл Сүхбаатар аймгийн БОГ-аараар гаргуулан ажиллаж байна. /хавсралт/</p>	<p>Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль M84992:2000 MNS85029:2011 MNS86458:2014</p>

“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан


	Үйлдвэрийн хатуу, шингэн хог хаягдал дахь химийн бодисын үлдэгдэл хэмжээг тодорхойлох хяналт шинжилгээ хийх	2024 оны 10.21 ны өдөр ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН-Д хүчилийн тодорхойлуулах хийлгэсэн. /хавсралт/	азотын агуулга шинжилгээ
--	---	---	--------------------------



Камер болон гэрэлтүүлэг



тэмдэг тэмдэглэгээ



Азот болон флокулянт аюулгүй ажиллагааны зааварчилгаа

“Эм Эл Цахиурт овоо” ХХК

Хуудас 37

8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 онд Цахиурт Овоо төмрийн хүдрийн ил уурхай нь олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулах ба төслийн үйл ажиллагааны явцад ахуйн хог хаягдал, үйлдвэрийн хог хаягдлыг ялгаруулах тул хог хаягдлын менежментийг холбогдох хууль журмын дагуу боловсруулсан болно. 2024 оны үйл ажиллагааны туршид Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хог хаягдлын төлөвлөгөөг мөрдлөг болгон ажиллаа.

Энэ онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагааны явцад үйлдвэрлэлийн болон ахуйн хаягдлаас үзүүлэх урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Хагуу хог хаягдлын цэгийг тэмдэгжүүлсэн.
- Хаягдал тосыг тусгай саванд цуглуулсан.
- Цаасны төрлийн хог хаягдлыг шатааж устгадаг.
- Хийсч тарсан болон уурхайн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж хэвшсэн.
- Хог хаягдал ангилан ялгах цэг байгуулсан.
- Уурхайн кемп болон үйлдвэр оффисд зориултийн стандартын шаардлага хангасан хогийн сав байршуулсан.
- Ахуйн хог, энгийн хог, аюултай хог, хог хаягдлын хор уршигийн талаар ажиллагсад сургалт явуулсан.
- Аюултай хог хаягдлыг нэр төрөл бүрээр бүртгэж түр хадаглах зөвшөөрлийн Сүхбаатар аймгийн БОАЖГ-аараас авсан.
- Сүхбаатар аймгийн ОНӨТҮГ-аартай Ахуйн болон энгийн хог хаягдлын тээвэрлэх гэрээ хийсэн./Хавсралт/



“Эм Эл Цахиурт овоо” ХХК

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**



Ахуйн болон энгийн хог хаягдлын цэг



Орчны цэвэрлэгээ хийгдэж байгаа байдал



ОНӨТҮГ азартай гэрээний дагуу хог хаягдал
хүргүүлж буй байдал

Ахуйн хог хаягдал: Энэ жилийн хугацаанд ахуйн хог хаягдал 21 м3 хог хаягдал гаргаж ахуйн хог хаягдлын савнуудад цуглуулж ахуйн хог хаягдлыг Сүхбаатар ОНӨТҮГ азартай гэрээний дагуу хогийн цэгт хүргүүлэн ажиллаа.

**“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**



Сүхбаатар аймаг ОНӨТҮГазрын хогийн цэг

Аюултай хог хаягдал: Төсөл хэрэгжих явцад үйл ажиллагааны явцад химийн хоргоос бодисын хувьд аюултай хортой хог хаягдал гэвэл аккумулятор, баттерей, ашиглагдсан шатах тослох материал, тос маслоны сав, тостой алчуур ашигласан фольклянтын шуудай, азотын сав гэх мэт зүйлүүд орох бөгөөд эдгээрийг тусад нь цуглуулж аюултай хог хаягдлын бүртгэл хийж хадгалж байгаа болно.



Аюултай хог хаягдал хадгалж буй байдал

9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Эм Эл Цахиурт Овоо” ХХК төмрийн хүдрийн уурхай нь 2024 оны БОМТөлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхдээ дараах удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг барьж ажиллаж байна.

- Монгол улсын байгаль орчны багц хууль, журам болон стандартуудыг хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд төрийн захиргааны байгууллагуудын хяналт шалгалтаар гарсан зөрчилгүй.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайланг холбогдох журмын дагуу боловсруулж орон нутаг болон БОАЖЯаманд хүргүүлдэг.
- Галын аюулгүй байдлын дүгнэлтийг Онцгой байдлын хэлтэсээр гаргуулав.
- 2024 оны Байгаль орчны мониторингийн судалгааг Сүхбатар аймгийн ус цаг уур орчны шинжилгээний төвөөр гүйцэтгүүлэв
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10-р зүйлийн дагуу байгаль орчны Аудитыг мэргэжилийн байгуулагаар хийж гүйцэтгүүлэв
- Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэв.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд
 - Уулбаян сумын нутагт 4-р багийн, цасанд боогдсон айл өрхүүдэд машин техник гарган ажилсан.
 - Хамжихгүй бол амжихгүй аяны хүрээнд манай компани нэгдэж нийт 6 мянга малын сэг зэмийг тээвэрлэн авчирч ариутгал хийж булшилтаг устгав.



Мониторинг



Аудит

“Эм Эл Цахиурт овоо” ХХК төмрийн хүдрийн ордыг ашиглах үед хэрэгжүүлэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Малын сэг зэм



Ариутгал



Дээрхи ажлийг зурагаар баталгаажуулав

10. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн болно. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн сум багийн иргэдийн хуралд БОМТ-ний төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар тайлан тавихаар төлөвлөсөн боловч цас зудтай байсан тул нийт 15 өрхөөр орж уурхайн талаар санал асуулага авч, өмнөх оны тайлан болон энэ оны төлөвлөгөөг танилцуулсан болно.



№	Огноо өгч	Төлөвлөгөөний зөвшөөрлийн талаар үзэл	Гарын үсэг
1	Бат- Батбаяр	Мэдээлэл үзсэн ч нэг шигшрүүлж өгөхгүй	Батбаяр
2	Арван- Бадарцаа	Ажлын үр дүнд нь олон агуулан, үзсэн арван жилийн туршид хүндэтгэж үзсэн ажлын үр дүнд нь	[Signature]
3	Арван- Дорно	Мэдээлэл нь тунгалаа үзсэн, хэргээр нь үзсэн үзсэн үзсэн үзсэн үзсэн үзсэн үзсэн үзсэн үзсэн	[Signature]
4	Арван- Анхбаяр	агуулан саналтай байна	Анхбаяр
5	Арван- Орвог	Дугуй үзэж үзсэн хэргээр үзсэн үзсэн үзсэн үзсэн үзсэн үзсэн үзсэн	[Signature]

“ЭМ ЭЛ Цахирт овоо” ХХК-ны 2024 онд Байгаль орчны
менежментийн төлөвлөгөөний төсөв.

№	Төлөвлөгөөнүүд	Төсөв/сая төгрөг/	Зарцуулалт /сая төгрөг/
1	Сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээ	10,550.00	11,531.00
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10,577,70	6,325.00
3	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	30,000,00	45,000.00
4	Орчны хяналт шинжилгээжний хөтөлбөр	4,160,00	5,123.00
5	Дүйцүүлэн хамгаалах хөдөлбөр	9,500,00	10,112.00
6	Химийн бодис эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон хог хаягдал	9,050,00	8,345.00
7	Нийт	73,837,700	86,436.00

Дүгнэлт

“ЭМ ЭЛ Цахиурт Овоо” ХХК нь Сүхбаатар аймгийн Уубаян сумын нутагт орших Цахиурт Овоо төмрийн хүдрийн ордын хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулах үйл ажиллагаа явуулахдаа бид хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, компанийн ажилчид болон нутгийн иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэндэд хохирол учруулахгүй, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах зорилго тавьж хяналт шинжилгээг хийлгэн ажиллаа. 2024 оны менежментийн төлөвлөгөөнд нийт 86.436.00сая төгрөг зарцуулсан байна.

Бид цаашдын үйл ажилгаанд орчны хяналт шинжилгээний хөдөлбөрийг тогтмол хугацаанд хийлгэж, сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээнд нэн шаардлагатай ажлуудыг тусган бүрэн гүйцэтгэж ажиллана. Ирэх онд ногоон байгууламж сайжруулах хөндөг хаягдлын менежментийг сайжруулах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг үргэлжлүүлэн хийх зэрэг ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч ажиллах болно. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны А-618 тоот журмын дагуу боловсрууллаа.

МОНИТОРИНГ